

I. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Үндэсний статистикийн хорооны 2023 оны III дугаар улирлын байдлаар Монгол Улсад 15 ба түүнээс дээш хөдөлмөрийн насны 2,136.7 мянган хүн байгаагийн 1,259.4 мянга нь ажиллах хүч, 877.3 мянга нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна.

Хүснэгт 1: Хөдөлмөрийн зах зээлийн үндсэн үзүүлэлт¹

Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	2022	2023 /3-р улирал/
15 ба түүнээс дээш насны хүн ам /мян.хүн/	2,220.4	2,226.5	2,106.0	2,128.1	2,152.1	2,159.6	2,136.7
Ажиллах хүч /мян.хүн/	1,357.4	1,358.6	1,273.9	1,250.6	1,225.4	1,265.2	1,259.4
Ажиллагчид /мян.хүн/	1,238.4	1,253.0	1,146.1	1,162.9	1,125.6	1,180.4	1,193.3
Ажилгүй иргэд /мян.хүн/	119	105.6	127.7	87.7	99.8	84.7	66.0
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам /мян.хүн/	863	867.9	832.1	877.5	926.7	894.3	877.3
Ажил хайгч иргэний тоо /мян.хүн/	37.1	36.2	37	30	28	21.2	8.5 /11 cap/
Бүртгэлтэй ажилгүй иргэд /мян.хүн/	25.5	25	20.7	18.1	18.6	13.9	6.3 /11 cap/
Ажиллах хүчний оролцооны түвшин /хувь/	61.1	61	60.5	58.8	56.9	58.6	58.9
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин /хувь/	55.8	56.3	54.4	54.6	52.3	54.7	55.9
Ажилгүйдлийн түвшин /хувь/	8.8	7.8	10.0	7	8.1	6.7	5.2
Ядуурлын түвшин /хувь/	-	28.4	-	27.8	-	-	-
Ажлын байрны захиалгын тоо	62,574	64,478	71124	58,022	51,034	55,211	69,926 /11 cap/
Ажилд зуучлагдсан иргэний тоо	45,683	43,105	44059	33,006	29,929	32,290	26,249 /11 cap/
Шинэ ажлын байранд орсон иргэний тоо	27,284	27,146	33,325	31,800	28,390	27,390	29,220 /11 cap/
Гадаадад ажиллах хүч илгээх үйлчилгээ авсан иргэний тоо	36,574	58,078	92,517	30,498	49,449	35,769	25,076 /11 cap/
Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлөөр ажиллаж буй гадаадын ажиллах хүч, мэргэжилтний тоо	4,703	4,502	4,601	5,058	4,039	3,943	10,817 /11 cap/
БНСУ-д ажиллахаар хил нэвтэрсэн иргэдийн тоо	1,058	784	633	63	176	863	743 /11 cap/
Япон Улсад ажиллахаар хил нэвтэрсэн иргэдийн тоо	-	-	-	-	12	137	95 /11 cap/

¹ www.1212.mn

Хүснэгт 2: Ажиллагчид²

№	Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар	2017	2018	2019	2020	2021	2022	2023 оны /3-р улирал/
1	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	356,423	334,101	290,160	276,455	277,783	293,974	295,233
2	Уул уурхай, олборлолт	52,017	57,687	57,923	51,575	56,226	60,342	62,187
3	Боловсруулах үйлдвэрлэл	93,062	100,805	90,378	89,722	81,630	112,665	104,825
4	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	17,458	16,307	19,348	14,380	16,775	22,040	20,123
5	Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	4,864	6,869	10,786	8,314	5,894	6,835	12,850
6	Барилга	70,604	76,596	68,847	77,279	80,866	77,527	89,401
7	Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	204,474	211,187	160,405	166,590	143,466	146,236	160,444
8	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	72,702	73,567	61,123	66,541	67,193	68,175	73,270
9	Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	36,449	37,484	36,280	29,991	34,537	32,019	36,494
10	Мэдээлэл, холбоо	14,490	14,089	13,019	18,830	18,956	19,155	16,372
11	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	24,120	25,689	24,257	29,355	29,158	22,570	19,431
12	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	379	770	1,154	3,411	2,580	2,472	598
13	Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	12,743	14,608	18,031	11,612	17,152	15,132	16,179
14	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	20,832	18,185	20,163	18,050	12,960	13,930	12,778
15	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	82,236	76,197	85,965	83,369	90,422	82,129	66,461
16	Боловсрол	98,876	98,738	96,108	110,735	111,299	104,397	119,948
17	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	39,973	49,462	44,376	60,189	47,133	49,659	46,862
18	Урлаг, үзвэр, тоглоом, наадам	10,104	13,835	17,999	10,812	6,350	14,114	7,328
19	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	22,728	23,364	24,547	29,752	24,096	34,180	31,159
20	Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	2,294	1,226	3,275	3,292	2,635	951	1018
21	Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	1,505	2,256	2,014	2,641	-	1,974	359
Бүгд		1,238,333	1,253,023	1,146,161	1,162,912	1,127,111	1,180,474	1,193,320

² www.1212.mn

Хүснэгт 3: Ажиллах хүчнээс гадуурх хүн ам³

№	Ажилгүй байгаа шалтгаан	2021 он			2022 он			2023 оны /3-р улирал/		
		Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй
	Дүн	878156	336655	541502	894357	343034	551323	877266	313448	563819
1	Хөдөлмөрийн нас хүрээгүй	783	0	783	3538	1385	2153	4537	3185	1352
2	Суралцдаг	232717	108642	124075	242573	119665	122908	238968	106022	132946
3	Тэтгэвэрт гарсан	344453	125729	218724	336505	118338	218166	337154	107132	230022
4	Өвчтэй	24201	15329	8872	39975	20564	19411	33506	18494	15012
5	Хөгжлийн бэрхшээлтэй	46011	23562	22449	39837	21864	17973	49418	29505	19913
6	Жирэмсэн/хүүхэд асарсан	111662	4466	107197	114681	1995	112687	125838	5473	120365
7	Бусдыг асарсан	20710	5166	15544	18364	6192	12172	15351	5023	10327
8	Тухайн жилд цэргээс халагдсан	354	354	0	628	628	0	310	310	0
9	Тухайн жилд сургууль төгссөн	2567	812	1756	3100	1242	1858	5502	3672	1830
10	Шилжин суурьшсан	0	0	0	599	217	382	574	0	574
11	Аав, ээж, гэр бүл, үр хүүхдээ дагаад	2992	609	2383	3660	1517	2143	1931	1257	673
12	Хүүхдээ сургуульд сургахаар	6446	774	5672	11778	1848	9930	6012	349	5662
13	Гадаадад амьдарч байгаад ирсэн	655	0	655	2150	1101	1049	2635	955	1681
14	Засан хүмүүжүүлэх газраас суллагдсан	0	0	0	137	137	0	0	0	0
15	Байгууллага татан буугдсан	3908	3418	490	293	0	293	2029	1241	789
16	Цомхотголд орсон	2593	1892	700	1123	718	405	410	410	0
17	Улирлын чанартай ажил хийдэг болохоор	9786	8930	857	8448	6691	1757	4006	2613	1393
18	Мэргэжил, дадлага туршлага байхгүй	5738	3438	2299	9930	5279	4651	9616	5114	4501
19	Мэргэжилд тохирох ажил олдохгүй	4071	387	3684	3899	2369	1530	3957	2372	1584
20	Ажил хайгаад олдохгүй байгаа	11447	7078	4368	8072	4436	3636	3542	2242	1300
21	Байгалийн гамшиг, аюулт үзэгдэлд өртөж малгүй болсон (ган, зуд, үе)	0	0	0	0	0	0	0	0	0
22	Ажиллах сонирхолгүй байсан	2337	653	1684	4910	3054	1855	7611	3303	4308
23	Цалин бага учраас	1550	426	1125	2500	1402	1098	4043	3257	786
24	Малчин	13401	7483	5918	19920	12127	7793	9444	5874	3571
25	Цар тахлын улмаас	14095	7415	6680	4730	2570	2160	160	160	0
26	Бусад	15679	10092	5587	11796	6676	5120	10712	5485	5227

³ www.1212.mn

II. АЖИЛ ХАЙГЧ БОЛОН БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭН


Ажил хайгч: 2023 оны 11 дүгээр сарын байдлаар аймаг, дүүргүүдийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдэд ажил идэвхтэй хайж буй ажил хайгч иргэдийн тоо **8489** болж өмнөх сараас 1484 хүнээр буюу 21.2 пунктээр өссөн ба өмнөх оны мөн үеэс **13943** хүнээр буюу 62.2 пунктээр буурсан байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэд: 2023 оны 11 дүгээр сарын байдлаар аймаг, дүүргүүдийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдэд бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо **6298** болж өмнөх сараас 1200 хүнээр буюу 23.5 пунктээр өссөн ба өмнөх оны мөн үеэс **8516** хүнээр буюу 57.5 пунктээр буурсан байна.

Хүснэгт 4: Ажил хайгч болон бүртгэлтэй ажилгүй иргэдийг байршилаар харуулвал


№	Аймаг, бүсээр	Ажил хайгч	Үүнээс эмэгтэй	Бүртгэлтэй ажилгүй иргэн	Үүнээс эмэгтэй
Баруун бүс		1824	944	1343	699
1	Баян-Өлгий	139	62	133	59
2	Говь-Алтай	472	230	408	202
3	Завхан	498	271	403	225
4	Увс	260	134	223	114
5	Ховд	455	247	176	99
Хангайн бүс		1543	870	1258	710
6	Архангай	362	163	294	130
7	Баянхонгор	194	112	176	103
8	Булган	141	64	96	46
9	Орхон	540	379	427	299
10	Өвөрхангай	57	31	45	24
11	Хөвсгөл	249	121	220	108
Төвийн бүс		1615	789	1094	569
12	Говьсүмбэр	219	106	111	52
13	Дархан-Уул	246	133	166	97
14	Дорноговь	201	97	189	92
15	Дундговь	134	81	124	76
16	Өмнөговь	185	79	136	61
17	Сэлэнгэ	446	190	237	115
18	Төв	184	103	131	76
Зүүн бүс		1091	609	975	540
19	Дорнод	347	162	325	148
20	Сүхбаатар	315	181	267	149
21	Хэнтий	429	266	383	243
Улаанбаатар		2416	1429	1628	912
22	Хан-Уул	166	113	99	70

23	Багануур	127	72	101	53
24	Баянзүрх	438	300	208	130
25	Налайх	159	98	126	74
26	Баянгол	286	167	177	104
27	Сүхбаатар	134	93	73	50
28	Чингэлтэй	162	99	94	59
29	Багахангай	35	17	21	8
30	Сонгинохайрхан	909	470	729	364
УЛСЫН ДҮН		8489	4641	6298	3430





Нийт ажил хайгч иргэдийн 1824 буюу 21.5 хувь нь Баруун бүсэд, 1543 буюу 18.2 хувь нь Хангайн бүсэд, 1615 буюу 19.0 хувь нь Төвийн бүсэд, 1091 буюу 12.9 хувь нь Зүүн бүсэд, 2416 буюу 28.5 хувь нь Улаанбаатарт байна.


Ажил хайгч иргэд: бүсээр, хүйсээр



Ажил хайгч иргэдийг насны бүлгээр авч үзвэл 17.3 хувь буюу 1469 нь 15-24 насны, 32.7 хувь буюу 2776 нь 25-34 насны, 28.2 хувь буюу 2397 нь 35-44 насны, 16.6 хувь буюу 1413 нь 45-54 насны, 3.2 хувь буюу 269 нь 55-59 насны, 1.9 хувь буюу 165 нь 60-аас дээш насныхан эзэлж байна.



Ажил хайгч иргэдийг боловсролоор: Нийт ажил хайгч иргэдийн 89 буюу 1.0 хувь нь магистр, доктор, 2117 буюу 24.9 хувь нь дипломын дээд болон бакалаврын, 379 буюу 4.5 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 661 буюу 7.8 хувь нь техникийн болон мэргэжлийн, 4047 буюу 47.7 хувь нь бүрэн дунд, 713 буюу 8.4 хувь нь суурь, 378 буюу 4.5 хувь нь бага, 105 буюу 1.2 хувь нь боловсролгүй иргэд эзэлж байна.




Нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн 1343 буюу 21.3 хувь нь Баруун бүсэд, 1258 буюу 20.0 хувь нь Хангайн бүсэд, 1094 буюу 17.4 хувь нь Төвийн бүсэд, 975 буюу 15.5 хувь нь Зүүн бүсэд, 1628 буюу 25.8 хувь нь Улаанбаатарт байна.



Бүртгэлтэй ажилгүй иргэдийг насны бүлгээр авч үзвэл 14.8 хувь буюу 930 нь 15-24 насны, 33.3 хувь буюу 2096 нь 25-34 насны, 29.6 хувь буюу 1867 нь 35-44 насны, 17.1 хувь буюу 1080 нь 45-54 насны, 3.2 хувь буюу 201 нь 55-59 насны, 2.0 хувь буюу 124 нь 60-аас дээш насныхан эзэлж байна.



Бүртгэлтэй ажилгүй иргэд: боловсролоор: Нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн 76 буюу 1.2 хувь нь магистр, доктор, 1740 буюу 27.6 хувь нь дипломын болон бакалаврын, 274 буюу 4.4 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 541 буюу 8.6 хувь нь техникийн болон мэргэжлийн, 2695 буюу 42.8 хувь нь бүрэн дунд, 574 буюу 9.1 хувь нь суурь, 312 буюу 5.0 хувь нь бага, 86 буюу 1.4 хувь нь боловсролгүй иргэд эзэлж байна. Нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн 3430 буюу 54.5 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.



III. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээ:

Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ үзүүлсэн байдлыг 2023 оны 11 дүгээр сарын байдлаар авч үзвэл:

- Зорилтот бүлгээр ганцаарчилсан хэлбэрээр зөвлөгөө, мэдээлэл авсан 7115 нийт иргэн, үүнээс эмэгтэй 4180 байна.
- Зорилтот бүлгээр бүлгийн сургалт, зөвлөгөөний хэлбэрээр ажил, үйлчилгээнд хамрагдсан 45370 иргэн, үүнээс эмэгтэй 22377 байна.

Дээрх үйлчилгээнд хамрагдаж үйлчилгээ авсан байгууллагын тоо 1879, үйлчилгээ авсан нийт иргэд 52485 үүнээс эмэгтэй 26557 байна.

Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, мэдээллээр хангах үйлчилгээний ганцаарчилсан зөвлөгөө авсан байдлыг байршлаар харуулвал

№	Аймаг, дүүрэг, байгууллагаар	Ганцаарчилсан зөвлөгөө авсан хүний тоо	Үүнээс эмэгтэй	Бүлгийн зөвлөгөө авсан хүний тоо	Үүнээс эмэгтэй
1	Баруун бүс-Дүн	1231	713	6354	3459
2	Баян-Өлгий	206	95	1431	756
3	Говь-Алтай	130	92	214	98
4	Завхан	15	10	276	112
5	Увс	670	403	2423	1410
6	Ховд	210	113	2010	1083
7	Хангайн бүс-Дүн	1384	884	5855	3150
8	Архангай	146	95	489	245
9	Баянхонгор	27	16	440	174
10	Булган	324	197	333	120
11	Орхон	188	144	662	306
12	Хөвсгөл	397	263	744	323
13	Өвөрхангай	302	169	3187	1982
14	Төвийн бүс-Дүн	1772	1016	7003	3509
15	Говьсүмбэр	119	60	361	187
16	Дархан-Уул	310	220	2931	1568
17	Дорноговь	33	23	416	182
18	Дундговь	847	479	526	214
19	Сэлэнгэ	101	40	645	378
20	Төв	327	171	1051	529
21	Өмнөговь	35	23	1073	451
22	Зүүн бүс-Дүн	1054	603	4946	2624
23	Дорнод	275	112	1654	890
24	Сүхбаатар	114	74	950	502
25	Хэнтий	665	417	2342	1232
26	Улаанбаатар	1674	964	21210	9633
27	Багануур	233	147	2449	1171
28	Багахангай	13	4	523	241
29	Баянгол	331	194	6873	3111
30	Баянзүрх	12	9	813	425


31	Налайх	370	180	2628	1274
32	Сонгинохайрхан	360	215	1653	706
33	Сүхбаатар	139	85	1667	688
34	Хан-Уул	28	14	197	95
35	Чингэлтэй	188	116	4407	1922
36	УЛСЫН ДҮН	7115	4180	45370	22377

Ажлын байрны захиалга: Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагуудын үйл ажиллагааны хүрээнд хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг ажил олгогчдоос ирүүлж буй ажлын сул байрны захиалгаар, нийлүүлэлтийг ажиллахад бэлэн ажил идэвхтэй хайж буй бүртгэлтэй ажилгүй иргэдээр тооцож байгаа ба ажлын байрны хомсдолоос шалтгаалан эрэлт, нийлүүлэлтийн харьцаа харилцан адилгүй байна.

Ажил олгогчдоос ирүүлсэн ажлын байрны захиалгын ашиглалт аймаг, нийслэлд ялгаатай байна. Тухайлбал аймгийн дунджаар 64 хувьтай байхад нийслэлд 72 хувьтай байна. Улсын хэмжээнд ажлын байрны ашиглалт 79 хувьтай байна.


Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг ажил олгогчдоос ирүүлж буй ажлын байрны захиалгаар, нийлүүлэлтийг ажил идэвхтэй хайж буй бүртгэлтэй иргэдээр тооцов.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг сүүлийн 3 жилээр харуулвал:



2023 оны 11 дүгээр сард ажил олгогчдоос нийт **69926** ажлын байрны захиалга ирүүлсэн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад тайлант хугацаанд ажил олгогчдоос ирүүлсэн ажлын байрны захиалга 24676 буюу 54.5 хувиар өссөн байна.

Ажлын байрны захиалгыг байршилаар





Хүснэгт 6: Ажлын байрны захиалгыг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар

№	Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал	Ажил олгогчдоос ирүүлсэн ажлын байрны захиалгын тоо	Эзлэх хувь %/
1	Хөдөө аж ахуй, загас барилт, ан агнуур	10496	15.0
2	Уул уурхай олборлолт	5784	8.3
3	Боловсруулах үйлдвэр	10310	14.7
4	Цахилгаан, хий, уур агааржуулалт	877	1.3
5	Усны хангамж бохир ус зайлуулах систем хог хаягдал	1671	2.4
6	Барилга	6245	8.9
7	Бөөний ба жижиглэнгийн худалдаа үйлчилгээ	9838	14.1
8	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	905	1.3
9	Зочид буудал, зоогийн газар	2446	3.5
10	Мэдээлэл холбоо	1303	1.9
11	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	697	1.0
12	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	144	0.2
13	Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	453	0.6
14	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	2447	3.5
15	Төрийн удирдлага болон батлан хамгаалах үйл ажиллагаа	6587	9.4
16	Боловсрол	5736	8.2
17	Эрүүл мэнд, нийгмийн халамж	1977	2.8
18	Урлаг үзвэр тоглоом наадам	318	0.5
19	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	1524	2.2
20	Хүн хөлслөн ажиллуулдаг, өрхийн аж ахуй	153	0.2
21	Олон улсын байгууллага суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	15	0.0
	ДҮН	69926	100


Хүснэгт 7: Ажлын байрны захиалгыг ажил мэргэжлийн ангиллаар

№	Ажил мэргэжлийн ангилал	Ажил олгогчдоос ирүүлсэн ажлын байрны захиалгын тоо	Эзлэх хувь /%/
1	Менежер	3038	4.3
2	Мэргэжилтэн	13753	19.7
3	Техникч болон туслах /дэд мэргэжилтэн/	5410	7.7
4	Контор үйлчилгээний ажилтан	1631	2.3
5	Худалдаа үйлчилгээний ажилтан	10449	14.9
6	ХАА, загас ан агнуурын ажилтан	2764	4.0
7	Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	8050	11.5
8	Суурин төхөөрөг, машин механизмын операторч, угсрагч	3954	5.7
9	Энгийн ажил, мэргэжил	1700	2.4
10	Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	19177	27.4
ДҮН		69926	100

Ажилд зуучлах үйлчилгээ: 2023 оны 11 дүгээр сарын байдлаар ажил олгогчдоос нийт **69926** ажлын байрны захиалга ирүүлснээс **26249** иргэнийг эдгээр ажлын байранд ажилд зуучлан оруулсан байна. Энэ нь ажлын байрны ашиглалт 37 хувьтай байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад ажилд зуучлан оруулсан хүний тоо 39 хүнээр буюу 1 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.




Ажилд зуучлагдсан иргэн байршил, хүйсээр харуулвал




Нийт ажилд зуучлагдан орсон иргэдийг ажил мэргэжлийн ангиллаар авч үзвэл:

Ажилд зуучлагдан орсон иргэд ажил мэргэжлийн ангиллаар



Ажилд зуучлагдан орсон иргэдийг насны бүлэг, хүйсээр авч үзвэл:




Ажлын шинэ байр: Улсын хэмжээнд 2023 оны 11 дүгээр сард нийт **29220** ажлын шинэ байр бий болж, түүнд ажилгүй иргэдийг бүрэн байршуулсан байна. Тайлант хугацаанд нийт **29220** ажлын шинэ байрыг бүртгэж тухайн ажлын байранд ажилд орсон иргэдийн мэдээллээр баталгаажуулсан байна. Ажлын шинэ байранд

ажилд орсон иргэдийг өмнөх оны мөн үетэй харьцуулан авч үзвэл **7816** хүнээр буюу **27.0** хувиар өссөн үзүүлэлттэй байна.



Нийт шинэ ажлын байрнаас байнгын шинэ ажлын байр 16818 буюу 57.6 хувь, улирлын шинэ ажлын байр 2244 буюу 7.7 хувь, түр шинэ ажлын байр 10158 буюу 34.8 хувийг тус тус эзэлж байна.

Ажлын шинэ байранд орсон иргэдийг байршил, хүйсээр авч үзвэл:



ХӨДӨЛМӨРИЙН ХУВИЙН БИРЖИЙН ТАЙЛАН

Хөдөлмөрийн биржийн сарын мэдээ тайланг шалгаж, санхүүжилт олгох үйл ажиллагааг зохион байгуулсан бөгөөд хөдөлмөрийн хувийн биржээр дамжуулан үзүүлсэн хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг 2023 оны 11 дүгээр сарын байдлаар өссөн дүнгээр авч үзвэл:

- Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөгөө өгсөн: 7305
- Бүлгийн зөвлөгөө өгсөн: 1149 бүлэг
- Ажилд зуучилсан хүний тоо: 1216
- 3 сар тогтвортой ажилласан иргэн: 414
- 6 сар тогтвортой ажилласан иргэн: 232
- 12 сар тогтвортой ажилласан иргэн: 251

Нийт олгосон санхүүжилт: 523,105,220 төгрөг зарцуулсан байна.

IV. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан 2023 онд хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа/хөтөлбөр/, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн А/16 дугаар тушаалаар батлагдсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны нэгдсэн удирдамжийн дагуу хэрэгжүүлж байна.

№	ҮЗҮҮЛЭЛТ	2023 ОНЫ БАТЛАГДСАН ТӨСӨВ		2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ /11 сар/		НИЙТ ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВЬ	
		ХҮН	ХӨРӨНГӨ	ХҮН	ХӨРӨНГӨ	/Хүний тоогоор/	/Мөнгөн дүнгээр/
1	Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ	163485	2,060,935,200	78734	1,224,625,671.3	48.2	59.4
2	Хөдөлмөрт бэлтгэх сургалтыг үйл ажиллагаа	21754	2,071,489,000	16017	1,103,616,740	73.6	53.3
3	Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	5966	35,509,774,000	6639	27,487,543,939	111.3	77.4
4	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа	5388	11,400,012,000	4752	9,075,515,641	88.2	79.6
5	Түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагаа	24657	10,844,000,000	20703	7,281,196,822	84.0	67.1
НИЙТ		221250	61,886,210,200	126845	46,172,498,813.3	57.3	74.6